



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2008 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

“Урт хугацааны даатгалын хураамжийн
хэмжээг тооцох журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 болон Даатгалын тухай хуулийн 14.2.9 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. ”Урт хугацааны даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Даатгалын тухай хуулийн 7.2 болон 14.2.5-д “даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал” гэж заасны дагуу энэ журмыг мөрдлөг болгоно.

1.2. Энэхүү журмын зорилго нь урт хугацаат даатгалын хураамжийн хэмжээ (цаашид “даатгалын хураамжийн хэмжээ” гэх)-г тооцох, даатгалын хураамжийн хэмжээнд өөрчлөлт оруулах, даатгалын хураамжийн хэмжээг тооцсон актуарын тооцоололт, судалгааны материалыг хянах харилцааг зохицуулахад оршино.

1.3. Энэ журам нь урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгагч (цаашид “даатгагч” гэх)-д хамаарна.

ХОЁР. Даатгалын хураамжийн хэмжээ

2.1. Даатгалын хураамжийн хэмжээг даатгалын цэвэр хураамж болон даатгалын нэмэлт хураамжийн нийлбэр дүнгээр тооцно.

2.2. Даатгалын цэвэр хураамжаар даатгалын тохиолдол гарахад даатгуулагчдад гэрээний дагуу нөхөн төлбөр олгох зориулалттай нөөцийн санг бүрдүүлнэ.

2.3. Даатгалын нэмэлт хураамжаар даатгалын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бүх төрлийн зардал болон бизнесийн ашгийг бүрдүүлнэ.

2.4. Даатгалын хураамжийн хэмжээг тогтоохдоо дараах зарчмыг баримтлана:

2.4.1. Даатгалын хураамжийн хэмжээ нь даатгагч, даатгуулагч нарын эрх ашигт нийцсэн байх;

2.4.2. Даатгагч нь хамгийн бага даатгалын хураамжийн хэмжээг тогтоож мөрдсөнөөр хамгийн олон даатгуулагчдыг хамруулах;

2.4.3. Даатгалын хураамжийн хэмжээг тогтвортой байлгах;

2.4.4. Даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр олгож, үйл ажиллагааны зардлыг бүрэн нөхөх;

2.4.5. Урт хугацаат даатгалын бүтээгдэхүүн (цаашид “даатгалын бүтээгдэхүүн” гэх)-ий гэрээний нөхцөлтэй уялдсан байх.

2.5. Даатгалын хураамжийн хэмжээг даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр тооцоолох бөгөөд даатгалын хураамжийг нэг удаа бүрэн төлөх, эсвэл даатгалын гэрээний хугацаанд үе шаттайгаар хэсэгчлэн төлөх хэлбэртэй байж болно.

ГУРАВ. Даатгалын цэвэр хураамжийн хэмжээг тооцох

3.1. Даатгалын цэвэр хураамжийн хэмжээг урт хугацааны актуарын тооцооллын аргаар дараах зүйлийг үндэслэн тооцно:

3.1.1. Хүн амын насжилтын хүснэгт;

3.1.2. Хүн амын нас баралтын түвшин;

3.1.3. Даатгалын хураамжийн хүүгийн түвшин.

3.2. Хүн амын насжилтын хүснэгт (цаашид “насжилтын хүснэгт” гэх) болон хүн амын нас баралтын түвшин (цаашид “нас баралтын түвшин” гэх)-г Үндэсний статистикийн хорооноос гаргасан хүн амын насны ангилал, наслалт, нас баралтын олон жилийн статистик судалгаа болон Эрүүл мэндийн хөгжлийн хүрээлэнгээс гаргасан хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааныг судалсан мэдээллийг үндэслэн тогтооно. Хэрэв манай орны насжилтын хүснэгтийг гаргахад мэдээлэл дутагдах тохиолдолд бүс нутгийн ижил төстэй бусад орны насжилтын хүснэгтийг өөрийн нөхцөлд тохируулан ашиглаж болно.

3.3. Насжилтын хүснэгтийг тухайн даатгалын гэрээ байгуулсны дараах 5 жилийн хугацаанд өөрчлөхгүй тогтвортой мөрдөх зарчмыг баримталж боловсруулна.

3.4. Даатгалын цэвэр хураамжийн тооцоонд нас баралтын түвшний өөрчлөлтийг хүйсээр болон бусад төрлийн ангилалаар судлан гаргаж тусгана.

3.5. Даатгалын хураамжийн хүүгийн түвшинг даатгагчаас даатгуулагчид санал болгож байгаа даатгалын хураамжийн баталгаат хүү болон даатгагчийн мөнгөн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийж олох хүүгийн тооцоолол дээр үндэслэн тогтооно.

3.6. Даатгалын цэвэр хураамжийн хэмжээг тооцоход шаардлагатай бусад судалгааг ашиглаж болно.

3.7. Даатгагч даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн нөөц сан тооцох актуар тооцооллын аргачлал, томъёоллыг Хороонд ирүүлсэн байна. [Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 252 дугаар тогтоолоор нэмэлт орсон/](#)

3.8. Даатгагч насжилтын хүснэгтийг өөрчлөх тохиолдолд өөрчлөх болсон шаардлага, тооцооллыг боловсруулан эрх бүхий актуарчаар баталгаажуулж Хороонд ирүүлнэ. [Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 252 дугаар тогтоолоор нэмэлт орсон/](#)

3.9. Хорооны актуарч даатгагчаас ирүүлсэн насжилтын хүснэгтийг өөрчлөх болсон шаардлага, ирүүлсэн тооцоолол нь үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлтээ үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай тайлбараа даатгагчид албан бичгээр хүргүүлнэ. [/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 252 дугаар тогтоолоор нэмэлт орсон/](#)

3.10. Даатгагч нь Хорооноос үндэслэлтэй гэж үзсэн буюу шинэчлэгдсэн насжилтын хүснэгтийг ашиглан хураамжийн болон нөөц сангийн тооцооллыг хийнэ. [/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 252 дугаар тогтоолоор нэмэлт орсон/](#)

3.11. Шинэчлэгдсэн насжилтын хүснэгт нь зөвхөн шинээр байгуулах гэрээний хувьд үйлчилж эхлэх бөгөөд өмнө нь байгуулсан даатгалын гэрээний хураамжид өөрчлөлт орохгүй болно. [/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 252 дугаар тогтоолоор нэмэлт орсон/](#)

ДӨРӨВ. Даатгалын нэмэлт хураамжийн хэмжээг тооцох

4.1. Даатгалын нэмэлт хураамжид дараах зүйлийг оруулж тооцно. Үүнд:

- 4.1.1. Даатгагчийн үндсэн үйл ажиллагааны зардал;
- 4.1.2. Даатгагчийн үндсэн бус үйл ажиллагааны зардал;
- 4.1.3. Давхар даатгалын зардал;
- 4.1.4. Даатгалын төлөөлөгчийн шимтгэл;
- 4.1.5. Даатгалын гэрээний дагуу олгох нөхөн төлбөр;
- 4.1.6. Хөрөнгө оруулалттай холбоотой зардал;
- 4.1.7. Даатгагчийн ашиг (алдагдал);
- 4.1.8. Бусад зардал.

4.2. Даатгалын нэмэлт хураамжийн хэмжээг тооцохдоо энэ журмын 4.1-д заасан зардал тус бүрээр нарийвчилсан тооцоолол хийнэ.

ТАВ. Даатгалын хураамжийн тооцооллыг баталгаажуулах

5.1. Даатгагч даатгалын хураамжийн хэмжээг тооцсон дараах тооцооллыг эрх бүхий актуарчаар баталгаажуулж Хороонд ирүүлнэ. Үүнд:

- 5.1.1. Энэ журмын 3.1-д заасан актуарын тооцоолол;
- 5.1.2. Энэ журмын 4.2-т заасан даатгалын нэмэлт хураамжийн тооцоолол;
- 5.1.3. Тухайн даатгалын бүтээгдэхүүний зах зээлийн хамралтын судалгаа;
- 5.1.4. Хөрөнгө оруулалтын 5 жилийн төлөвлөгөө;

5.1.5. Даатгалын гэрээнд заасан бусад хураамжийн хэмжээтэй холбоотой өөрчлөлтийн судалгаа, тооцоолол.

5.2. Даатгагчаас ирүүлсэн даатгалын хураамжийн тооцооллыг Хорооны актуарч ажлын 15 хоногийн дотор хянаж, дүгнэлт гаргана.

5.3. Хорооны актуарч даатгагчаас ирүүлсэн даатгалын хураамжийн тооцооллыг шаардлага хангасан гэж үзвэл дүгнэлтээ Хорооны хуралдаанд танилцуулж, тухайн даатгалын бүтээгдэхүүний зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлүүлнэ.

5.4. Хорооны актуарч даатгагчаас ирүүлсэн даатгалын хураамжийн тооцооллыг шаардлага хангаагүй гэж үзвэл энэ тухай тайлбар үндэслэлээ даатгагчид албан бичгээр хүргүүлнэ.

5.5. Хороо даатгагчийн сонгосон аргачлалыг шаардлага хангахгүй гэж үзвэл энэ тухай тайлбар, үндэслэлийг албан бичгээр даатгагчид хүргүүлнэ.

ЗУРГАА. Хяналт тавих

6.1. Даатгагч нь Хорооноос зөвшөөрөл авсан даатгалын бүтээгдэхүүний хураамжийн хэмжээг үндэслэн үйл ажиллагаагаа явуулна.

6.2. Хороо шаардлагатай гэж үзвэл энэ журмын 5.1-д зааснаас гадна нэмэлт судалгаа тооцоолол, үндэслэлийг даатгагчаас шаардаж, тодруулга тайлбар авч болно.

6.3. Даатгагч даатгалын хураамжийн хэмжээг өөрчлөх тохиолдолд Хороонд албан бичгээр мэдэгдэж, энэхүү журмын дагуу шинэчлэн тооцоолсон даатгалын хураамжийн үндэслэл тооцооллыг ирүүлнэ.

6.4. Тухайн даатгалын бүтээгдэхүүний даатгалын хураамжийн хэмжээг өөрчлөх тухай даатгагчийн хүсэлтийг Хорооноос хянаж шийдвэр гаргал өмнөх даатгалын хураамжийн хэмжээ хүчинтэй байна.

6.5. Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--